

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Агуулга

Бүлэг 1. Төслийн товч танилцуулга.....	3
1.1. Төслийн танилцуулга.....	3
1.2. Төслийн эдийн засгийн үзүүлэлт	9
1.3.Төслийн талбайн дэд бүтэц, усан хангамж, цахилгаан хангамж	10
Бүлэг 2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	12
Бүлэг 3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	14
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	16
3.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт	16
3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор болох арга хэмжээний төлөвлөгөө	16
3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	16
3.6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17
3.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
3.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	19
3.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах хэлэлцүүлэх төлөвлөгөө	20
Дүгнэлт.....	22

Зургийн жагсаалт

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил.....	4
Зураг 2. План зураг	5
Зураг 3. Агуулах байрлах сандвичэн барилга	8
Зураг 4. Химийн бодисоо хадгалах контейнер	9

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн координат	3
Хүснэгт 2. Химийн бодисын агуулахад хадгалагдах бодисын жагсаалт	6
Хүснэгт 3. Төслийн эдийн засгийн үзүүлэлт	9
Хүснэгт 4. Химийн бодисын зардал.....	9
Хүснэгт 5. Химийн бодисын тээвэрлэлт	10
Хүснэгт 6. Ажилчдын цалингийн жилийн хэмжээ	10
Хүснэгт 7Төслийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	12
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	16
Хүснэгт 10. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	19

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 13. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	20
Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	21
Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	23

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг 1. Төслийн товч танилцуулга

1.1. Төслийн танилцуулга

Төслийн нэр: Химийн бодисын агуулах

Төсөл хэрэгжүүлэгч: "Долоон болдог" ХХК

Регистрийн дугаар: 2819449

Үүсгэн байгуулагдсан он: 2004 он

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 20-р хороо Үйлдвэрийн баруун бүс, Эрчим хүчний гудамж, 62 62/1 62/2 тоот хаалга Утас: 77008080, 77003939

Төслийн байршил: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, 4-р цахилгаан станцын баруун талд 20000м² га талбайтай хашаан дотор байрлана.

Хүснэгт 1. Төслийн талбайн координат

№	X	Y
1	5307936.59	633860.76
2	5307936.25	633857.42
3	5307975.81	633853.78
4	5308114.45	633843.50
5	5308114.45	633843.50
6	5308114.08	633839.54
7	5308117.96	633839.39
8	5308121.65	633839.14
9	5308125.32	633840.83
10	5308131.46	633841.95
11	5308127.00	633847.47
12	5308135.46	633867.62
13	5307984.88	633879.99
14	5307976.74	633867.75
15	5307908.55	633874.96
16	5307907.61	633863.00

Төслийн зорилго: Монгол улсад үйлдвэрлэх боломжгүй будаг шингэлэгч, хатаагч, цэвэрлэгээний шингэн зэргийг чанар стандартын шаардлагын дагуу импортлон оруулж ирэх, технологи, стандартын дагуу аюул осолгүй хадгалж, ашиглан, тусгай стандартын будгийн кабинд тавилгын зориулалттай будгийг шингэлж тавилга будах, тоног төхөөрөмж цэвэрлэн Kitchen all брэндийн гал тогооны тавилга үйлдвэрлэж хэрэглэгчдэд хүргэхэд зорилго оршино.

Зорилтууд:

- Импортыг орлох өндөр чанартай гэр ахуйн бүх төрлийн тавилгыг Монголдоо үйлдвэрлэнэ.
- Европын бүрэн автомат стандарт үйлдвэрлэлийг европын 1 зөвлөх, 6 мэргэжилтэнтэй хамтран 2 жилийн хугацаанд нэвтрүүлэх замаар бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэнэ.
- Үйлдвэрлэлийг автоматжуулсанаар өртөг буурч, эцсийн бүтээгдэхүүний үнэ 30%-иар буурна.


БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдсэнээр ажилчдын цалин 30-40%-иар нэмэгдэнэ.
- Борлуулалт, гадаад худалдаа болон орон нутгийн салбаруудад ажлын байр 20-25%-иар нэмэгдэнэ.
- Дотоодын тавилгын хэрэгцээг хангахын сацуу ОХУ болон Казакстанруу бүтээгдэхүүн экспортлоно.
- Ажилчдын орон сууц, хүүхдийн цэцэрлэг, спортын танхим, ногоон байгууламж бүхий үйлдвэрлэлийн парк болон үзүүлэнгийн дэлгүүрийг шинээр ашиглалтанд оруулна.

Үйл ажиллагаа:


- Гал тогооны тавилга үйлдвэрлэл
- Хувцасны шкаф үйлдвэрлэл
- Гал тогооны цахилгаан бараа худалдаа
- Импортын тавилга худалдаа

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зураг 2. План зураг



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Химийн бодисын агуулах нь 29,72 м² талбайтай 2-3 тн бодис хадгалах хүчин чадалтай. Агуулахад нийт 3 хүн ажиллах бөгөөд будгийн үйлдвэрийн дарга, будгийн үйлдвэрийн мэргэжилтэн, нярвууд ажиллана.

Хүснэгт 2. Химийн бодисын агуулахад хадгалагдах бодисын жагсаалт

№	Бодисын нэр	Олон улсын нэр	Томьёо	CAS дугаар	Жилийн хэрэгцээ	Импортлох улс	Химийн боомт
1	Шингэлэгч DF-M002	PU THINNER	C ₂ H ₅ COCH ₃	78-93-3	1тн	Итали	Алтанбулаг боомт
			CH ₃ COO(CH ₂) ₃ CH ₃	123-86-4			
			C ₆ H ₄ (CH ₃) ₂	1330-20-7			
			CH ₃ COOC ₂ H ₅	141-78-6			
			CH ₃ CO ₂ CH(CH ₃)CH ₂ OCH ₃	108-65-6			
			C ₆ H ₅ C ₂ H ₅	100-41-4			
2	Шингэлэгч DF-M003	PU THINNER	CH ₃ COO(CH ₂) ₃ CH ₃	123-86-4	8тн	Итали	Алтанбулаг боомт
			CH ₃ CO ₂ CH(CH ₃)CH ₂ OCH ₃	108-65-6			
3	Шингэлэгч DF-M600	PU THINNER	(CH ₃) ₂ CHCH ₂ COCH ₃	108-10-1	1тн	Итали	Алтанбулаг боомт
			CH ₃ CO ₂ CH(CH ₃)CH ₂ OCH ₃	108-65-6			
			C ₆ H ₁₀ (=O)	108-94-1			
4	Шингэлэгч DT-M070	STAIN THINNER	CH ₃ COCH ₃	67-64-1	1тн	Итали	Алтанбулаг боомт
5	Шингэлэгч DT-M071	STAIN THINNER	CH ₃ CH(OH)CH ₂ OCH ₃	107-98-2	1тн	Итали	Алтанбулаг боомт
6	Шингэлэгч DT-M075	STAIN THINNER	C ₄ H ₉ OCH ₂ CH ₂ OH	111-76-2	1тн	Итали	Алтанбулаг боомт
7	Хатууруулагч FC-M007	NON-YELLOWING PU HARDENER	CH ₃ COO(CH ₂) ₃ CH ₃	123-86-4	1тн	Итали	Алтанбулаг боомт
			C ₂ H ₅ COCH ₃	78-93-3			
			C ₁₇ H ₁₈ N ₄ O ₄	26426-91-5			
			C ₉ H ₆ N ₂ O ₂	26471-62-5			
			OCN(CH ₂) ₆ NCO	822-06-0			
8	Хатууруулагч FC-M011	HARDENER FOR CLEAR BASE COAT AND TOP COAT	CH ₃ COO(CH ₂) ₃ CH ₃	123-86-4	2тн	Итали	Алтанбулаг боомт
			C ₆ H ₅ CH ₃	108-88-3			
			CH ₃ COOC ₂ H ₅	141-78-6			
			C ₉ H ₆ N ₂ O ₂	9017-01-0			
			C ₁₉ H ₃₀ N ₂ O ₈	53317-61-6			
9	Хатууруулагч FC-M021	NON-YELLOWING PU HARDENER	CH ₃ COO(CH ₂) ₃ CH ₃	123-86-4	1тн	Итали	Алтанбулаг боомт
			C ₂ H ₅ COCH ₃	78-93-3			
			C ₁₇ H ₁₈ N ₄ O ₄	26426-91-5			
			(C ₈ H ₁₂ N ₂ O ₂) _x	28182-81-2			
10	Хатууруулагч FC-M040	NON-YELLOWING PU HARDENER	CH ₃ COO(CH ₂) ₃ CH ₃	123-86-4	3тн	Итали	Алтанбулаг боомт
			C ₉ H ₆ N ₂ O ₂	9017-01-0			
			(C ₈ H ₁₂ N ₂ O ₂) _x	28182-81-2			
			C ₂ H ₅ COCH ₃	78-93-3			

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

11	Хатууруулагч FC-M042	PU HARDENER	$\text{CH}_3\text{COO}(\text{CH}_2)_3\text{CH}_3$	123-86-4	3тн	Итали	Алтанбулаг боомт
			$\text{CH}_3\text{COOC}_2\text{H}_5$	141-78-6			
			$\text{C}_9\text{H}_6\text{N}_2\text{O}_2$	9017-01-0			
			$\text{C}_{19}\text{H}_{30}\text{N}_2\text{O}_8$	53317-61-6			
			$\text{C}_2\text{H}_5\text{COCH}_3$	78-93-3			
			$\text{C}_9\text{H}_6\text{N}_2\text{O}_2$	26471-62-5			
12	Хатууруулагч FC-M070	NON- YELLOWING PU HARDENER	$(\text{C}_8\text{H}_{12}\text{N}_2\text{O}_2)_x$	28182-81-2	2тн	Итали	Алтанбулаг боомт
			$\text{CH}_3\text{COO}(\text{CH}_2)_3\text{CH}_3$	123-86-4			
			$\text{C}_2\text{H}_5\text{COCH}_3$	78-93-3			
			$\text{CH}_3\text{COOC}_2\text{H}_5$	141-78-6			
13	Хатууруулагч FC-M194	PU HARDENER	$\text{CH}_3\text{COOC}_2\text{H}_5$	141-78-6	1тн	Итали	Алтанбулаг боомт
			$\text{C}_{21}\text{H}_{12}\text{N}_3\text{O}_6\text{PS}$	4151-51-3			
			$\text{C}_6\text{H}_5\text{Cl}$	108-90-7			
14	Хатууруулагч FC-M199	PU HARDENER	$\text{CH}_3\text{COO}(\text{CH}_2)_3\text{CH}_3$	123-86-4	2тн	Итали	Алтанбулаг боомт
			$\text{C}_9\text{H}_6\text{N}_2\text{O}_2$	9017-01-0			
			$\text{CH}_3\text{COOC}_2\text{H}_5$	141-78-6			
			$\text{C}_2\text{H}_5\text{COCH}_3$	78-93-3			
			$\text{CH}_2(\text{C}_6\text{H}_4\text{NCO})_2$	101-68-8			
15	Хатууруулагч FC-M640	PU HARDENER FOR HIGH- GLOSS TOP COAT	$\text{CH}_3\text{COO}(\text{CH}_2)_3\text{CH}_3$	123-86-4	1тн	Итали	Алтанбулаг боомт
			$(\text{C}_8\text{H}_{12}\text{N}_2\text{O}_2)_x$	28182-81-2			
			$\text{C}_9\text{H}_6\text{N}_2\text{O}_2$	9017-01-0			
			$\text{C}_2\text{H}_5\text{COCH}_3$	78-93-3			
			$\text{CH}_3\text{CO}_2\text{CH}(\text{CH}_3)\text{CH}_2\text{OCH}_3$	108-65-6			
16	Цэвэрлэгээний шингэн LPZ/II	Release agent	$\text{CH}_3\text{CH}_2\text{OH}$	64-17-5	1тн	Итали	Алтанбулаг боомт
17	Цэвэрлэгээний шингэн LP163/93	Cleaning agent	$\text{CH}_3\text{CH}_2\text{OH}$	64-15-5	1тн	Итали	Алтанбулаг боомт
18	Цавуу	Formaglu S30M	$\text{CH}_4\text{N}_2\text{O}$	57-13-6	1тн	Грек	Алтанбулаг боомт
19	Аммонийн хлорид	Hardener C10	NH_4CL	7446-70-0	1тн	Грек	Алтанбулаг боомт
20	Шээг	Urea resin powder	$\text{CH}_4\text{N}_2\text{O}$	57-13-6	1тн	Грек	Алтанбулаг боомт
21	Суурь цавуу	YC-M419	$\text{HOCH}_2\text{CH}_2\text{OH}$	22237-13-4	500kg	Итали	Алтанбулаг боомт
22	Өнгөлөгч JB- M671	JB-M671 HIGH GLOSS ACRYLIC TOP COAT, HIGH BUILD	$\text{C}_6\text{H}_{12}\text{O}_3$	108-65-6	2 тн	Итали	Алтанбулаг боомт
			$\text{C}_7\text{H}_{14}\text{O}$	110-43-0			
			$\text{CH}_3\text{COO}(\text{CH}_2)_3\text{CH}_3$	123-86-4			
			CH_3COCH_3	67-64-1			
			$\text{C}_8\text{H}_{14}\text{O}_2$	97-86-9			
			$(\text{CH}_3\text{O})\text{C}_3\text{H}_6\text{OC}_3\text{H}_6(\text{OH})$	34590-94-8			

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зураг 3. Агуулах байрлах сендвичэн барилга



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зураг 4. Химийн бодисоо хадгалах контейнер



1.2. Төслийн эдийн засгийн үзүүлэлт

Будган тавилга нь манай компанийн борлуулалтын 17-30%-г эзэлдэг бөгөөд будган тавилга борлуулж эхэлснээс хойш манай 1 сарын борлуулалт 12-23%-р нэмэгдсэн. Төслийн хэрэгжүүлэх үед 1 жилд дунджаар дараах зардлууд гарна.

Хүснэгт 3. Төслийн эдийн засгийн үзүүлэлт

№	Зардлын нэр	Зардал сая.төг
1	Химийн бодисын зардал	390.0
2	Химийн бодисын тээвэрлэлт	30.8
3	Ажилчдын цалингийн жилийн хэмжээ	26.4
	Нийт зардал	447.2 сая.төг

Хүснэгт 4. Химийн бодисын зардал

Бодисын нэр	Үнэ
Будаг шингэлэгч	159 600 000
Хатаагч	40 356 000
Будаг	166 744 000
Цэвэрлэгээний шингэн	23 300 000

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Химийн бодисын тээвэрлэлт

Зориулалт	Үнэ
Итали-Улаанбаатар тээвэр	30 800 000

Хүснэгт 6. Ажилчдын цалингийн жилийн хэмжээ

Ажилчид	Нэгж цалин	Жилийн хэмжээ
Будгийн үйлдвэрийн дарга	900 000	10 800 000
Нярав	500 000	6 000 000
Мэргэжилтэн	800 000	9 600 000

1.3.Төслийн талбайн дэд бүтэц, усан хангамж, цахилгаан хангамж

Дэд бүтэц: Энэхүү химийн бодисын агуулах нь Баянгол дүүргийн 20-р хороо Үйлдвэрийн баруун дүүрэг, Эрчим хүчний гудамжинд байрлаж байгаа бөгөөд Сонсголон Монос чиглэлийн төв замаас 500 метр 4 цахилгаан станц ТӨХК-ийн баруун талд байрлаж байна. Дэд бүтэц сайн хөгжсөн бүс юм.

Усан хангамж: Химийн бодисын агуулах талбайн бүх барилга нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон бөгөөд УСУГ-тай цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ байгуулан ажиллаж байна.

Цахилгаан хангамж: ДЦС-2 ТӨХК-тай 2017 оны 05-р сарын 1-нээс эхлэн гэрээ байгуулан цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна. 2020 оны 11-р сарын 1нд “Зитоп” ХХК-тай цахилгаан эрчим хүч, ус, дулаанаар хангах гэрээ хийсэн ба 2023 оны 11-р сарын 1-ний өдөр хүртэлх хугацаатайгаар байгуулсан.

Энэхүү гэрээгээр дулаан, эрчим хүч, усыг гэрээнд заасан тоо, чанарын түвшинд худалдах /халаалт, хэрэглээний халуун хүйтэн ус, цахилгаан/, хэрэглээний төлбөрөө тогтоосон хугацаанд бүрэн төлөх, талууд харилцан эрх эдлэж, үүрэг хүлээх, хариуцлага хүлээлгэхтэй холбоотойгоор хангагч талаас тавих технологийн гомдолтой холбоотой шаардлагыг хэрэглэгч тал ханган биелүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

Химийн бодис тээвэрлэлт: Долоон болдог ХХК нь Цэцүүх трейд ХХК-тай Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2 -р хавсралт болох “Аюултай хог хаягдал түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах устгах болон бүртгэх тайлагнах журам”-д заасны дагуу аюултай хог хаягдал шилжүүлэх, тээвэрлүүлэх гэрээг байгуулан химийн бодисын сав баглаа боодлоо өгч устгуулж байна.

- * Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
- * Химийн хорт болон аюултай бодис хадгалах тээвэрлэх, ашиглах, устгах журам
- * Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм
- * НҮБ-аас 2002 оны 04 сард гаргасан “Аюултай ачаа бараа тээвэрлэх зөвлөмж, зохицуулалтын заавар”
- * MNS5029-2011 Химийн хорт бодисын шошго тэмдэглэгээ
- * MNS4978-2000 Аюултай ачаа, ангилал, техникийн шаардлага

Төслөөс гарах хог хаягдал

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Шингэн хаягдал: Төслийн үйл ажиллагаанаас технологийн бохир ус, шингэн хаягдал гарахгүй.

Хатуу хог хаягдал: Төслийг хэрэгжүүлэх явцад будаг шинэгэлэгч нь 25 литрээр төмөр лаазан саванд савлагддаг, цэвэрлэгээний шингэн нь 30 литрийн хуванцар саванд савлагддаг.

Хийн хаягдал: Төслийг хэрэгжүүлэх явцад будаг шингэлэгчийг будаг шингэлэх зориулалтаар стандартын будгийн цехэд найруулж будагдах тул хийн хаягдал гарахгүй.

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Бүлэг 2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Энэхүү бүс нутаг нь Улаанбаатар хот Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт хамаарах бөгөөд үнэлгээний судалгааны явцад цуглуулсан мэдээ, мэдээлэл, хээрийн судалгааны явцад хийсэн хэмжилтээс гарсан үр дүнг боловсруулсан болно. Төслийн барилгын ажил болон цаашдын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов. Нөлөөллийн хамрах хүрээг бүс нутаг, дүүрэг, хороо, төслийн талбай гэсэн үндсэн 4 түвшинд тодорхойлов.

Хүснэгт 7Төслийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ

№	Болзошгүй нөлөөлөл	Бүс нутгийн түвшинд	Дүүргийн түвшинд	Хороо буюу орон нутгийн түвшинд	Төслийн талбайн хэмжээнд	Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
1	Уур амьсгалын өөрчлөлт	0	0	0	0	
	Агаарын чанарын өөрчлөлт	0	х	х	х	Агаар бохирдож болзошгүй
	Чимээ шуугиан	х	х	х	х	Дуу чимээ, доргилт ихсэх
	Гадаргын болон гүний усны нөөц, горим	0	0	х	х	Төвийн шугамд холбогдсон.
	Хөрсний чанар, геоморфологи	0	х	х	х	Хөрсний элэгдэл эвдрэл үүснэ.
2	Усны ургамал, амьтан	0	0	0	0	
	Эх, газрын ургамал, амьтан	0	0	0	х	Ургамлын бүтэц өөрчлөгдөх
	Тусгай хамгаалалттай газар нутаг	0	0	0	х	
	Дархан цаазтай амьтан, ургамлын төрөл зүйл	0	0	0	х	
3	Аж үйлдвэр, зам тээвэр	0	0	х	х	зам тээвэр нэмэгдэнэ.
	Орон нутгийн усан хангамж	0	0	х	х	Усны хангамж доголдож болзошгүй.
	Хаягдал усны менежмент	0	0	0	х	Хаягдал ус гарна
	Хатуу хог хаягдлын менежмент	0	х	х	х	Хог хаягдлын төрөл, хэмжээ нэмэгдэж болзошгүй.
	Эрчим хүчний хэрэглээ, хангамж	х	х	х	х	Хэрэглээ нэмэгдэх магадлалтай.
4	Нийгэм-эдийн засгийн байдал	+	+	+	+	Ажлын байр, орлого нэмэгдэнэ.
	Археологи, палеонтологи	0	0	0	0	

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал	0	0	0	х	Агаарын бохирдлоос үүдэн өвчин эмгэг тохиолдож болзошгүй.
--	-------------------------------------	---	---	---	---	---

Жич: “Х”-сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай
 “О”-нөлөө үзүүлэхгүй
 “+”-эерэг нөлөө үзүүлэх тэмдгээр харуулав.

Бүлэг 3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Агуулах болон үйлдвэрийн байрны агааржуулалтын системийг шалгах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, тоосжилтыг бууруулахын тулд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, үйлдвэр болон оффист анхны тусламжийн хайрцгыг байршуулах, ажилчдын эмнэлгийн үзлэгт хамруулах, анхаарал болгоомжтой ажиллах, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулж байх, шинээр ажилд орох хүмүүсийг шалгаж, сургаж байх, агуулах болон үйлдвэрийн үйл ажиллагаанд химийн бодисын аюулгүй ажиллагааны журмыг боловсруулж мөрдөж ажиллах зэрэг ажлыг төлөвлөхөө.

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ	Нийт зардал	Хэрэгжүүлэгч	Баримтлах хууль, журам, стандарт
Агуулах болон үйлдвэрийн байрны агааржуулалтын системийг шалгаж байх	Агуулах болон үйлдвэрийн байр	Удаа	7 хоног бүр	Үйл ажиллагааны зардалд тусгасан.		ХАБЭА мэргэжилтэн	Хөдөлмөрийн аюулгүй байдлын журам
Ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	“Долоон болдог” ХХК-ийн хашаан дотор	ш	17	12000	204 000	ХАБЭА мэргэжилтэн	Хөдөлмөрийн аюулгүй байдлын журам
Тоосжилтыг бууруулахын тулд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Үйлдвэрийн барилгын гадна	м ²		Ногоон байгууламжийн зардалд тусгав.		ХАБЭА мэргэжилтэн	Газрын тухай хууль
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх хөрс, агаарын	Орчны хяналт шинжилгээний цэгүүд	Зүсэлтийн тоо, ширхэг	1 удаа	100 000	100 000	Захиргааны хэлтэс	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ
ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

шинжилгээ хийлгэхэд мэргэжлийн байгууллагаас дэмжлэг авах							
Үйлдвэр болон оффист анхны тусламжийн хайрцгыг байршуулах	Үйлдвэр болон оффист	Ш	4	50 000	200 000	ХАБЭА мэргэжилтэ н	Эрүүл мэндийг хамгаалах журам
Ажилчдын эмнэлгийн үзлэгт хамруулах	Ажилчид			ҮА зардалд тусгах		Захиргааны хэлтэс	
Химийн бодистой анхаарал болгоомжтой ажиллах, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулж байх, шинээр ажилд орох хүмүүсийг шалгаж, сургаж байх	Шинэ ажилчид	Ш	4 удаа	200 000	800 000	ХАБЭА мэргэжилтэ н	
Агуулах болон үйлдвэрийн үйл ажиллагаанд химийн бодисын аюулгүй ажиллагааны журмыг боловсруулж мөрдөж ажиллах	Агуулах болон үйлдвэр			ҮА зардалд тусгах			
Нийт зардал, төг					1304 000		

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Тоосжилтыг бууруулахын тулд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мод тарих, цэцгийн мандал байгуулах ажлуудыг төлөвлөсөн бөгөөд нийт 900 000 төгрөг зарцуулах бөгөөд энэхүү ажлыг өөрсдийн ажилчдын оролцоотой гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ	Нийт зардал	Хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
Тоосжилтыг бууруулахын тулд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мод тарих	Төслийн талбайн хэмжээ	Тоо, ширхэг	20 ширхэг	20000	400 000	ХАБЭА мэргэжилтэн	Ургаж буй модны тоо	Эвдэрсэн газрыг ургамалжуулахад “Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага” MNS 5918: 2023
Цэцгийн мандал байгуулах	Үйлдвэр, оффисын гадна талд	Ш	1000	500	500 000	ХАБЭА мэргэжилтэн	Ургаж буй цэцгийн мандал	
Нийт зардал, төг					900 000			

3.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт

Энэхүү төслийн хүрээнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгдөхгүй.

3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор болох арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжих талбайд айл өрх болон байгууламж байхгүй тул нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговор олгогдохгүй юм.

3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайд одоогоор ил харагдах түүх соёлын дурсгалт зүйлс тэмдэглэгдээгүй бөгөөд барилга байгууламжуудыг нэмж барьж байгуулах, барилгын суурь ухахад төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.2-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанд тавилга будах бэхжүүлэх, хатууруулах, цэвэрлэгээний шингэний зориулалтаар химийн бодис хэрэглэнэ. Химийн бодисын менежментийн төлөвлөгөөнд Химийн бодисын хэрэглээг хянах, бүртгэл хөтлөх, ажилчдыг химийн бодисын хороос хамгаалах саармагжуулах бүтээгдэхүүн аарц, сүү өгөх, химийн бодистой ажилдаг ажилчдад хамгаалах хэрэгсэл малгай бээлий хошуувч нүдний шил зэрэг хамгаалах хэрэгслээр хангах зэрэг ажлууд төлөвлөсөн бөгөөд нийт 434 000 төг зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 10. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ	Нийт зардал	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
Химийн бодисын хэрэглээг хянах, бүртгэл хөтлөх	Ашиглагдаж байгаа химийн бодисын тоо	Тоо	-	-	-	ХАБЭА мэргэжилтэн	-	Хөтлөлтийн тайлан	Химийн бодисын тухай хууль
Ажилчдыг химийн бодисын хороос хамгаалах саармагжуулах бүтээгдэхүүн аарц, сүү өгөх	Нийт ажилчид	Тоо	64 хүн	2875 төг	184 000	Захиргааны хэлтэс	-	Хэрэглэсэн бүтээгдэхүүний тоо	Эрүүл мэндийн тухай хууль, хөдөлмөр хамгаалал нийгмийн халамжийн тухай хууль
Химийн бодистой ажилдаг ажилчдад хамгаалах хэрэгсэл малгай бээлий хошуувч нүдний шил зэрэг	Нийт ажилчид	Тоо	10 хүн	25 000	250 000	Захиргааны хэлтэс	-	Хамгаалах хэрэгсэлийн тоо хэмжээ	Хөдөлмөр хамгаалал нийгмийн халамжийн тухай хууль

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ
ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

хамгаалах хэрэгслээр хангах									
Химийн бодистой харьцах ажилчдыг жилд 1 удаа сургалтад хамруулах	Ажилчи д	Удаа	1	500 000	500 000	ХАБЭА мэргэжилтэ н	Мэргэжлийн байгууллага ХАБЭА мэргэжилтэн		Химийн бодисын тухай хууль
Нийт зардал, төг					934 000				

3.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Долоон болдог ХХК Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ гэрээ байгуулан сардаа 1 удаа хог хаягдлаа тээвэрлүүлэн ачуулдаг байна. Энэхүү ажлын зардалд сард 65000 төг, жилд 780000 төгрөг зарцуулдаг байна.

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ	Нийт зардал	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг тусгайлан бэлдсэн цэгт хаяагүй, тогтсон хугацаанд ачуулах	Төслийн талбайн хэмжээнд	Тоо	Сард 1 удаа	65000	780 000	Аж ахуйн алба	Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ	Тээвэрлэсэн хогны хэмжээ	Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга
Химийн бодисын сав баглаа боодлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлж устгуулах	Химийн бодисын сав баглаа боодол	Удаа	2	350 000	700 000	Аж ахуйн алба	Элемент ХХК	Устгалд оруулсан химийн бодисын хэмжээ	Химийн бодисын тухай хууль, хог хаягдлын тухай хууль
Нийт зардал					1480 000				

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ
ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

3.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг төсөл хэрэгжих 20-р хорооны иргэдэд танилцуулах ажлыг хорооны байранд зар тавьж иргэдийн цуглуулж бага оврын автобусаар иргэдийн төслийн талбай рүү хүргэж танилцуулах ажлыг зохион байгуулна.

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хийгдэх арга хэмжээ	Хугацаа	Хамрах хүрээ	Нэгжийн зардал	Нийт зардал
Хорооноос зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээнд байгууллагаараа оролцох	Жилд 1 удаа	Агуулах орчмын талбай	500 000	500 000
Ажилчдыг эрүүл хөдөлгөөн арга хэмжээ зохион байгуулж хамруулах	Жилд 4 удаа	Бүх ажилчид	500 000	500 000
Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн.	Жилд 1 удаа	Бүх ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах	
Байгаль орчны төлөвлөгөөт аудитын тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх	3 улиралд	Төслийн хүрээнд		2000 000
Нийт зардал				3000 000

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ
ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

3.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах хэлэлцүүлэх төлөвлөгөө

Долоон болдог ХХК нь усан хангамжийн төвлөрсөн шугамд холбогдох учраас усны чанарын шинжилгээ хийгдэхгүй. 2025 оны байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд хөрсөн бүрхэвчээс 2 цэгт зүсэлт хийж дээж авч ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн хөрсний лабораторид хөрсний ерөнхий химийн шинжилгээ болон хүнд металаас кадми, зэс, хар тугалга, төмөр, цинк гэсэн 5 элементийг шинжлүүлэхээр төлөвлөж байна. БОТЛ-иар агаарын чанарын техникч нараар агаарын шинжилгээг хийлгэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 13. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал	Дээд доод хязгаар
<i>Хөрсний чанар</i>							
Хөрсний механик бүрэлдэхүүн	Төслийн талбайн дотор 2 цэгт	1 удаа 10 дугаар сард	2 цэгт	1*60 000 төг	120 000	MNS 5850-2008 Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодисы	
хүнд металаас кадми Cd, зэс Cu, хар тугалга Pb, төмөр Fe, цинк Zn	Төслийн талбайн дотор 2 цэгт	1 удаа 10 дугаар сард	2 цэгт	53570 төг	107140	элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
<i>Агаарын чанар</i>							
Тоосжилт PM10, SO2, NO2, CO	Төслийн талбайн дотор 2 цэгт	1 удаа 10 дугаар сард	2 цэгт	50500 төг	110 000	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2011 оны 10 сарын 10-ны өдрийн А-342 дугаар тушаалын хавсралтаар үнийг тооцов.	
Нийт дүн				337 140 төг			

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ
ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

3.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогт талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов /он. сар/	Зохион байгуулах газар
Баянгол дүүргийн 20-р хорооны иргэд	Танилцуулга хийх	Хийсэн ажлын тайланг танилцуулах	2025 оны 10 сар	Хорооны хурлын заал
БОУАӨЯ-ны холбогдох мэргэжилтэнүүд	Тайлан хүргүүлэх		2025 оны 11 сар	

Дүгнэлт

“Долоон болдог” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 Дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Химийн бодисын агуулах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

“Долоон болдог” ХХК Химийн бодисын агуулах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

Долоон болдог ХХК нь усан хангамжийн төвлөрсөн шугамд холбогдох учраас усны чанарын шинжилгээ хийгдэхгүй. 2025 оны байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд хөрсөн бүрхэвчээс 2 цэгт зүсэлт хийж дээж авч ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн хөрсний лабораторид хөрсний ерөнхий химийн шинжилгээ болон хүнд металаас кадми, зэс, хар тугалга, төмөр, цинк гэсэн 6 элементийг шинжлүүлэхээр төлөвлөж байна. БОТЛ-иар агаарын чанарын техникч нараар агаарын шинжилгээг хийлгэхээр төлөвлөсөн.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн байгаль орчны төлөвлөгөөт аудитын тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөсөн.

Нийт хийгдсэн ажлуудыг нэгтгэн дүгнэж хэрэгжүүлж эхэлсэн талаар БГД-н 29 дугаар хорооны иргэдийн төлөөллийн хурал, БГД-н Байгаль орчны газарт танилцуулга хийхээр төлөвлөсөн. Мөн тухайн жилийн биелэлтийн тайланг 2025 оны 11-р сарын 1-ны өдөр БОУАӨЯ болон БГД-н ЗДТГ-т хүргэн өгөхөөр төлөвлөсөн.

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

№	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	1304 000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	900 000
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1480 000
5	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	934 000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	337 140
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	3000 000
8	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө	500 000
	2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	8 455 140

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **8 455 140** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Энэхүү зардлын 50 хувь буюу 4 227 570 төгрөгийг байршуулна.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД БАЙРЛАХ ДОЛООН БОЛДОГ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ГОЛОМТ БАНК GOLMOT BANK		ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ/DEPOSIT SLIP	
Дансны дугаар / Account number:	Мөнгөн дүн / Amount:	Утас / Phone No:	
100200555301	4,227,570	99098801	
Тэмдэглэл / Note: (Дансны нэр, Дансны нэр, Гүйцэтгэлийн үйл)	Валютын код / Currency:	Иргэний бүртгэл № / ID No:	
Дансны нэр / Bank name:	MNT USD CNY EUR RUB JPY	1290140627	
Дансны дугаар / Account number:		Харилцагчийн гарын үсэг / Customer's signature:	
2025 09 18			
Огноо / Date:	385	Энэ баримтанд бичигдсэн мэдээллийн үнэн зөвийг хариуцаж гарын үсгээр баталгаажуулна. (I, hereby, sign to confirm the accuracy of the information provided here.)	
Салбар / Branch:	555379347	Дансхарт / Denomination:	Тоо / Quantity:
Гүйцэтгэлийн дугаар / Transaction No:	MOF (TREASURY FUND)	10	
100200555301		20	
Бэлтгэж байгаа / Bank name:	БГДНӨХӨН СЭРГЭЭЛТ	50	
Дансны дугаар / Account number:	4,227,570.00	100	
Данс эзэмшдэгч / Account holder:	MNT	500	
Гүйцэтгэлийн дүн / Transaction amount:	500.00	1,000	
Валютын код / Currency:	ДӨРВӨН Сая Хоёр зуун Хорин долоон мянга таван зуун далан төгрөг	5,000	
Гүйцэтгэлийн хураамт / Fee:		10,000	
Мөнгөн дүн үгээр / Amount in words:	Долоон бодог зог	30,000	
Гүйцэтгэлийн үйл / Description:		40,000	
Хараахан / Reviewed:	ХТБ / Total:	50,000	
		60,000	
		70,000	
		80,000	
		90,000	
		1,000,000	
		Sum / Total:	